

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

АУДИТЫН КОД: ТӨА-2023/11/НА-СТА-ОНА

ЭРДЭНЭ ТОХИЖИЛТ ОНӨААТҮГ-ЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод хот 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ихмонгол хөлөг Аудит ХХК

Утас: 70001778 Цахим хаяг: info@imkaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	7
3.1 Эрдэнэ тохижилт ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа	7
3.2 Эрдэнэ тохижилт ОНӨААТҮГ-ын гадаад, дотоод орчин.....	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	8
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт.....	8
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	9
4. АУДИТЫН ТАЙЛАН	10
4.1 Ерөнхий зүйл.....	10
4.2 Материаллаг байдал	10
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	10
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	10
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	13
5.1 Төлбөрийн акт	13
5.2 Албан шаардлага.....	13
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	15
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	15
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл.....	15
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
ИТХТХ	Иргэдийн хурлын тэргүүлэгчдийн хурал
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.03.16 № 01/218
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэ тохижилт ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрдэнэ тохижилт ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрдэнэ тохижилт ОНӨААТҮГ-ын 2022 оны зорилтот түвшний төлөвлөгөөгүй ажилласан байна.

Аудитын гол асуудал

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, дүрэмд заагдсан үйл ажиллагааг явуулаагүй, нягтлан бодох бүртгэлийг энгийн бүртгэлээр хөтөлсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Эрдэнэ тохижилт үйлдвэрийн газрын захирал нь Эрдэнэ сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 17 дугаар тогтоолоор баталсан ОНӨААТҮГ-ын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2.1-д "Газрын тухайн жилд хийгдэх их засварын нэгдсэн төлөвлөгөө, төсвийг батална", "7.2.4-т" Газрын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах хөрөнгийг батлах" гэж заасныг хэрэгжүүлээгүй", эдийн засгийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг батлаагүй, захиралтай гэрээ байгуулаагүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

19040220

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Мөрийн дугаар	Балансын зүйл	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	98,000.00	1,002,300.00
1.1.1.1	Эргэлтийн хөрөнгийн дүн	98,000.00	1,002,300.00
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	-	-
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	98,000.00	1,002,300.00
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.2	Цалингийн өглөг		-
2.1.1.3	Татварын өр		90,430.00
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	-	90,430.00
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	-	90,430.00
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч - төрийн		100,000.00
2.3.2	- хувийн	-	
2.3.3	- хувьцаат		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	98,000.00	811,870.00
2.3.11	Эздийн өмчийн дүн	98,000.00	911,870.00
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	98,000.00	1,002,300.00

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/			
Мөрийн дугаар	Балансын зүйл	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	100,000.00	24,635,000.00
2	Борлуулалтын өртөг		-
3	Нийт ашиг (алдагдал)	100,000.00	24,635,000.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,000.00	23,730,700.00
18	Татварын өмнөх ашиг (алдагдал)	98,000.00	904,300.00
19	Орлогын татварын зардал		90,430.00
20	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
21	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	98,000.00	813,870.00
22	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
24	Орлогын нийт дүн	98,000.00	813,870.00
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	-	-	-
2021 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл	-	98,000.00	98,000.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	100,000.00	(100,000.00)	-
Залруулсан үлдэгдэл	100,000.00	(2,000.00)	98,000.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		813,870.00	813,870.00
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	100,000.00	811,870.00	911,870.00

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	100,000.00	24,635,000.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	24,635,000.00
1.1.5	Бусад мөнгөн орлого	100,000.00	-
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,000.00	23,730,700.00
1.2.1	Ажиллагсдад олгосон мөнгө		1,212,400.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад олгосон мөнгө		-
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө		1,332,000.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн мөнгө		588,000.00
1.2.5	Шатахуун, тээврийн зардалд төлсөн мөнгө		20,568,200.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	2,000.00	30,100.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	98,000.00	904,300.00
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Гадаад валютын зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	98,000.00	904,300.00
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	98,000.00
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	98,000.00	1,002,300.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Эрдэнэ тохижилт ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа

Эрдэнэ тохижилт ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Эрдэнэ тохижилт ОНӨААТҮГ-ын зорилго нь: “Орон нутгийн өмчит нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт, ногоон байгууламж, авто зам, гүүр, гадаргуугийн болон хөрсний ус зайлуулах барилга байгууламжийн ашиглалт, засвар” гэж тодорхойлжээ.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд Орон нутгийн өмчит ААТҮГазар статустай Эрдэнэ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын харьяа байгууллага байна.

Үйлдвэрийн газрын дүрэмд “Газрын /ОНӨААТҮГ-ын өмчлөгч нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байх бөгөөд төлөөлөл хэрэгжүүлэгч нь сумын Засаг дарга байна.” гэж тодорхойлжээ.

3.2 Эрдэнэ тохижилт ОНӨААТҮГ-ын гадаад, дотоод орчин

Эрдэнэ тохижилт ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

Эрдэнэ тохижилт ОНӨААТҮГ нь Эрдэнэ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 17 дугаар тогтоолоор байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4-т “Орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна.

Тайлант тус газрын засаглалыг сайжруулах, эдийн засгийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг батлаагүй, захиралтай гэрээ байгуулаагүй байна.

Тайлант хугацаанд Эрдэнэ тохижилт ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 01 дүгээр сарын 01-ээс хэрэгжиж эхэлсэн.
- Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-д “Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн энэ хуулийн 21.1-д заасны дагуу ногдох албан татвар, 23.1-д заасны дагуу эдлэх хөнгөлөлтийг жилийн эцсийн тайлангаар эцэслэн тооцож тайлагнан, холбогдох татварыг төсөвт шилжүүлнэ”;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 203 дугаар тогтоол;
- Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай Сангийн 2022 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал.

Эрдэнэ тохижилт ОНӨААТҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд

хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт нөлөөгүй байна.

Эрдэнэ тохижилт ОНӨААТҮГ- дотоод хяналтын бодлого журамгүй, төлөвлөгөөгүй, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаагүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэ тохижилт ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Эрдэнэ тохижилт ОНӨААТҮГ-нь Нгятлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Эрдэнэ тохижилт ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллага нь НБББББ-ийг боловсруулан батлуулж мөрдөөгүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 904.3 мянган төгрөгөөр буюу 10.2 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	98.0	1,002.3	904.3
Нийт хөрөнгө	98.0	1,002.3	-904.3
Өр төлбөр	0	90.4	90.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	98.0	911.9	813.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	98.0	1,002.3	904.3

Дээрх хүснэгтээс харахад, мөнгөн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн дансны үлдэгдэл өмнөх оны үзүүлэлтээс өссөн байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 904.3 мянган төгрөгөөр өссөн нь нийт орлого өмнөх оноос өссөн нь нөлөөлсөн.
- Өр төлбөрийн дансны үлдэгдэл өмнөх оноос 90.4 мянган төгрөгөөр өссөн хувь хүний орлогын албан татварын өглөгийг бүртгэсэн нь гол нөлөөг үзүүлсэн.
- Эздийн өмчийн дансны үлдэгдэл 813.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн ашгийн бүртгэж тайлагнаснаас шалтгаалсан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Эрдэнэ тохижилт ОНӨААТҮГ нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрдэнэ тохижилт ОНӨААТҮГ-нь 2021 онд байгуулагдан үйл ажиллагаагаа эхэлсэн боловч, сумын ИТХТ, газрын удирдах зөвлөлөөс 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг батлаагүй, захиралтай гэрээ байгуулаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэ тохижилт ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Эрдэнэ тохижилт ОНӨААТҮГ түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Эрдэнэ тохижилт ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааг сайжруулах, төрийн хэмнэлтийн хуультай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Ариунбат, аудитор Д.Буянравжих, О.Эрдэнэчимэг, шинжээч Б.Ган-Эрдэнэ, Т.Оюун, аудитын менежер Б.Батцэцэг, Г.Ариунболд, аудиторын туслах З.Ариунцэцэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын мэргэжилтэн С.Сожидмаа, захирал С.Тунгалаг, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, Дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэ тохижилт ОНӨААТҮГ-нь 2022 оны санхүүгийн тайлангаа Ихмонгол хөлөг Аудит ХХК-д 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл **Дунд** гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Эрдэнэ тохижилт ОНӨААТҮГ-ын 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 23,730.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 237.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 166.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар баталсан заавар, журамгүй хэрэгжилтийг хангах талаар ямар нэгэн арга хэмжээг авч ажиллаагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллагын 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг байршуулаагүй Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1 удаагийн 6,000.0 мянган төгрөг, зарлагын 1 удаагийн 5,923.2 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага” гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-т “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Эрдэнэ тохижилт ОНӨААТҮГ-нь 2021 онд байгуулагдан үйл ажиллагаагаа эхэлсэн боловч, сумын ИТХТ, газрын удирдах зөвлөлөөс 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг батлаагүй, захиралтай гэрээ байгуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1/-д “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг / цаашид “захирал” гэх/ томилохдоо гэрээ байгуулна. Гэрээнд дараах нөхцөлийг тусгана: 2/-т “Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшин” гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-т “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Эрдэнэ тохижилт ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудитыг хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх онд санхүүгийн тайлан, зорилтот түвшний гүйцэтгэлд аудит хийгдээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төрийн болон орон нутгийн өмчийн, төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 248.0 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

- Тайлант онд нохой устгалын ажлын хөлснөөс ХХОАТ-т 148.0 мянган төгрөг суутган тооцсоныг өглөгөөр бүртгээгүй, татварын албанд тайлагнаж төлөөгүйг;
- Эрдэнэ сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 17 дугаар тогтоолын 1-д"..... 100,000.00(Нэг зуун мянган)төгрөгийн дүрмийн сантай " Эрдэнэ тохижилт үйлчилгээ" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг байгуулан ажиллуулсугай" гэж заасны дагуу тогтоосон дүрмийн санг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд бүртгэж тайлагнаагүйг байна.

Аудитаар нийт 2 зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоох зөрчил аудитын явцад илрээгүй.

5.2 Албан шаардлага

1. Эрдэнэ тохижилт ОНӨААТҮГ –ын захирал нь Эрдэнэ сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 17 дугаар тогтоолоор баталсан ОНӨААТҮГ-ын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2.1-д "Газрын тухайн жилд хийгдэх их засварын нэгдсэн төлөвлөгөө, төсвийг батална," 7.2.4-т "Газрын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах хөрөнгийг батлах", 8 дугаар зүйлийн 8.1.1-д "Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд, гарын дүрэм, зорилтын талаар санал, бизнес төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах", 8.1.9-д "Захирал нь үйл ажиллагааны тайлангаа сумын ИТХТХ, Засаг даргын зөвлөлийн хуралд хагас бүтэн жилээр тайлагнана гэж" заасныг хэрэгжүүлээгүй, ажлын тайлан бэлтгээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", 77 дугаар зүйлийн 77.3-т "Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг хувьчлах ба бусдад шилжүүлэх, шинээр олж авах жагсаалт, төлөвлөгөө, эх үүсвэрийг хэлэлцэж батлах. Хувьчлах орон нутгийн эд хөрөнгийн жагсаалтыг батлахдаа Төрийн өмчийн хороотой зөвшилцөнө", 19 дүгээр зүйлийн 1/-д "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг / цаашид "захирал" гэх/ томилохдоо гэрээ байгуулна. Гэрээнд дараах нөхцөлийг тусгана", 2/-т "Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшин" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

2. Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн маягтыг хөтлөх аргачлал" батлах тухай, 100 дугаар тушаалаар батлагдсан "Анхан шатны баримт, санхүүгийн тайлан тодруулгыг бэлтгэх зааврын дагуу бэлтгээгүй, энгийн бүртгэл хөтөлсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан

гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт

Байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг", 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын үйл ажиллагааны онцлог, стандарт, хууль дүрэмд нийцүүлэн НБББББ-ийг боловсруулан батлуулж мөрдөх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд нохой устгалын ажлын хөлснөөс ХХОАТ -т 148.0 мянган төгрөг суутган тооцсоныг өглөгөөр бүртгээгүй, татварын байгууллагад тайлагнаж төлөөгүй байна.	1	148.0	1	148.0			1	148.0				
Эрдэнэ сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 17 дугаар тогтоолын 1-д "..... 100,000.00 (Нэг зуун мянган) төгрөгийн дүрмийн сантай " Эрдэнэ тохижилт үйлчилгээ" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг байгуулан ажиллуулсугай" гэж заасны дагуу тогтоосон дүрмийн санг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд бүртгэж тайлагнаагүй байна.	1	100.0	1	100.0			1	100.0				
Дүн	2	248.0	1	148.0	0	-	1	148.0	-	-	-	-

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Эрдэнэ тохижилт ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан маягтын дагуу тайлагнасан. НББ-ийн хөтлөхдөө тодруулгыг бэлтгэх зааврын дагуу бэлтгээгүй, энгийн бүртгэл хөтөлсөн байна.	1	-			1	-						
Байгууллага нь НБББББ-гүй байна.	1	-					1	-				
Эрдэнэ сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 17 дугаар тогтоолоор баталсан ОНӨААТҮГ-ын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2.1-д "Газрын тухайн жилд хийгдэх их засварын нэгдсэн төлөвлөгөө, төсвийг батална", 7.2.4-т "Газрын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах хөрөнгийг батлах", 8 дугаар зүйлийн 8.1.1-д "Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд, гарын дүрэм, зорилтын талаар санал, бизнес төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах", 8.1.9-д "Захирал нь үйл ажиллагааны тайлангаа сумын ИТХТХ, Засаг даргын зөвлөлийн хуралд хагас бүтэн жилээр тайлагнана гэж" заасныг хэрэгжүүлээгүй, ажлын тайлан бэлтгээгүй байна.	1	-			1	-						
Дүн	3	-			2	-	1	-				

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тус байгууллагын 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг байршуулаагүй Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1 удаагийн 6,000.0 мянган төгрөг, зарлагын 1 удаагийн 5,923.2 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй байна.	1	11,923.20			1	11,923.20		
Дүн	1	11,923.2			1	11,923.2		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	11,923.2			1	11,923.2		